



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР  
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,  
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

---

## ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

---

|                    |  |
|--------------------|--|
| Судалгааны төрөл:  | Харьцуулсан судалгаа   |
| Судалгааны код:    | СТ-25/,,,  |
| Хугацаа:           | 2025.04.22   |
| Захиалагч:         | ПССХ-ийн удирдлага   |
| Хянасан:           | ПСХХ–ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Онолт<br>ПСХХ–ийн Судалгааны хэлтсийн дарга Г.Гэсэр |
| Судалгаа удирдсан: | ПСХХ–ийн Судалгааны хэлтсийн зөвлөх Г.Билгээ   |
| Судлаач:           | ПСХХ–ийн Судалгааны хэлтсийн ахлах референт<br>О.Нарантуяа                                   |

Улаанбаатар хот  
2025 он

## АГУУЛГЫН ТОВЬЁГ

|   |                                     |
|---|-------------------------------------|
| <b>ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ</b> .....   | <i>Error! Bookmark not defined.</i> |
| <b>УДИРТГАЛ</b> .....   | <i>ii</i>                           |
| <b>СУДАЛГААНЫ ҮР ДҮН</b> .....  | <b>3</b>                            |
| <b>ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ</b> .....  | <b>5</b>                            |
| <b>НЭГ.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙГ БҮРТГЭХ</b> .....  | <b>5</b>                            |
| 1.1.Эрх зүйн зохицуулалт .....  | 5                                   |
| 1.2.Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн тухай.....  | 6                                   |
| 1.3.Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг бүртгүүлэх.....  | 7                                   |
| 1.4.Хуулийн этгээдийн бүртгэлийн байгууллага .....  | 9                                   |
| <b>ХОЁР.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ОНООСОН НЭРИЙГ БАТАЛГААЖУУЛАХ</b> .....   | <b>10</b>                           |
| <b>ГУРАВ.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТАМГА ТЭМДГИЙН ХЭРЭГЛЭЭ</b> .....  | <b>12</b>                           |
| <b>ДӨРӨВ.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЦАХИМ ГЭРЧИЛГЭЭ</b> .....  | <b>14</b>                           |
| <b>ТАВ.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЦАХИМ БҮРТГЭЛИЙН СИСТЕМ</b> .....  | <b>15</b>                           |
| <b>ЗУРГАА.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ХУВЬ<br/>НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙГ БҮРТГҮҮЛЭХ</b> ..... | <b>16</b>                           |
| <b>ДОЛОО.ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ХОРШООГ БҮРТГЭХ ТУХАЙ</b> .....  | <b>18</b>                           |
| <b>НОМ ЗҮЙ</b> .....  | <b>20</b>                           |

## Хүснэгтийн жагсаалт

|   |    |
|---|----|
| Хүснэгт 1 Эцсийн өмчлөгч нэр томъёоны тодорхойлолт (Их Британи, АНУ, Франц, Нидерланд).....             | 6  |
| Хүснэгт 2 Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн бүртгүүлэх хугацаа .....                                  | 7  |
| Хүснэгт 3 Хуулийн этгээдийн бүртгэлийн байгууллага, бүртгэх хэлбэр, мэдээллийн ил тод байдал .....      | 9  |
| Хүснэгт 4 Хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулах, бүртгүүлэх (Их Британи, АНУ, Франц, Нидерланд) ..... | 11 |
| Хүснэгт 5 Хуулийн этгээдийн тамганы зохицуулалт, гарын үсгийн хэрэглээ .....                            | 13 |

## УДИРТГАЛ

**Судалгааны зорилго:**

**Судалгааны хамрах хүрээ:**

**Судалгааны арга зүй:**

**Судалгааны ажлын бүтэц:**

**Түлхүүр үг:**

**Монгол:**

**Англи:**

## СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд авагдсан улсууд хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг бүртгэх, ил тод болгохтой холбоотой харилцааг олон улсад нийтлэг хэрэглэж буй зөвлөмж, удирдамжийг баримтлахаас гадна дотоодын хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулж байна. Франц болон Нидерланд улс нь Мөнгө угаахтай тэмцэх тухай Европын Холбооны 4 болон 5 дахь удаагийн удирдамжийг дотоодын хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлж байна.

Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч нь тухайн хуулийн этгээдийг өмчилдөг, хяналт тавьдаг хувь хүн юм. Мөн хувьцаа эзэмдэг гэсэн нэрийдлээр итгэмжлэгдсэн этгээд, зуучлагчаар дамжуулан хяналт хэрэгжүүлж буй этгээд ч байж болно. Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (FATF)-аас гаргасан зөвлөмжийн 10-т эцсийн өмчлөгч гэж хуулийн этгээдийг шууд болон шууд бусаар өмчилж буй хувь хүнийг хэлнэ гэж тодорхойлжээ. Дэлхийн улсууд тус байгууллагаас гаргасан зөвлөмжид заасны дагуу хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг тодорхойлох, бүртгэх, хяналт тавих ажлыг зохион байгуулж байна.

Хуулийн этгээдийг бүртгэх, түүнд хяналт тавихтай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан байна. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг бүртгүүлэхдээ дараах нийтлэг мэдээллийг бүртгүүлнэ. Тухайлбал, Эцсийн өмчлөгчийн овог нэр, иргэншил, төрсөн огноо, оршин суугаа хаягийг заавал бүртгүүлэх бөгөөд оршин суугаа улс (Их Британи, Нидерланд), эзэмшиж, өмчилж буй хувь хэмжээ (Франц, Нидерланд), хяналтын төрөл (Их Британи, Франц) болон иргэний үнэмлэх/жолооны үнэмлэхний дугаар (АНУ, Нидерланд)-ыг мөн бүртгэдэг байна. Харин Их Британид эцсийн өмчлөгч болсон хугацааг бүртгүүлдэг онцлогтой.

Эцсийн өмчлөгчийн мэдээллийг бүртгүүлэх хугацааны хувьд, судалгаанд авагдсан улсууд харилцан адилгүй зохицуулалттай байна. Их Британи, АНУ, Франц улс нийтдээ 30 хоногт багтаан улсын бүртгэлд бүртгүүлдэг бол Нидерланд улсын хувьд хуулийн этгээдийн анх бүртгүүлэхдээ бүртгүүлдэг байна.

Хуулийн этгээдийг бүртгэх бүртгэлийн байгууллагын хувьд худалдааны асуудал эрхэлсэн байгууллага энэхүү чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Харин бүртгэх хэлбэрийн хувьд, нийтлэг цахимаар бүртгүүлэх бөгөөд зарим тохиолдолд цаасан хэлбэрийг шуудангаар илгээдэг. Харин бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн мэдээллийн ил тод байдлын хувьд Их Британи олон нийтэд нээлттэй, АНУ, Франц, Нидерланд улс олон нийттэй хаалттай байна. Гэхдээ хууль хяналтын байгууллага болон санхүүгийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан танилцах эрхтэй байна.

Судалгаанд авагдсан улсуудад хуулийн этгээдийн нэр авахдаа нэрийн давхардлыг заавал шалгах бөгөөд цахим системээс нэр шалгах бөгөөд зарим нэр авахад тусгай шаардлага тавьдаг байна. Жишээлбэл, Их Британид Royal, Bank, Institute, Government гэх мэт үг агуулсан бол тусгай зөвшөөрөл шаардлагатай.

Хуулийн этгээдийн нэрийг АНУ болон **Францад** урьдчилан хадгалуулдаг бол Их Британи болон Нидерландад урьдчилан хадгалуулах боломжгүй байна.

Хуулийн этгээдийн тамганы хэрэглээ, зохицуулалтыг авч үзвэл, тамганы хэрэглээний хувьд заавал биш бөгөөд тухайн компани дүрэмдээ заасны дагуу тамга хэрэглэж болно. Компанийн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг зурсан аливаа баримт бичиг хууль зүйн хүчинтэй бөгөөд цахим гарын үсэг нь бичгэн гарын үсгийн адил хүчин төгөлдөр байдаг байна.

Судалгаанд хамрагдсан улсуудын зохицуулалтаас үзэхэд, хуулийн этгээдийн гэрчилгээ нь цахим болон цаасан гэсэн хоёр хэлбэртэй байна. Цахим хэлбэрийг хуулийн

этгээдийн бүртгэлийн байгууллагад бүртгүүлснээр PFD хэлбэрээр татан авах боломжтой бөгөөд цахим хэлбэр нь хууль ёсны хүчин төгөлдөр байдаг бол зарим улсад дижитал баталгаажуулалттай (АНУ, Нидерланд). Хуулийн этгээдийн гэрчилгээ нь компанийн талаарх албан ёсны мэдээллийг агуулж байдаг тул 6-10 сарын хугацаанд хүчинтэй байх (АНУ, Нидерланд), эсхүл компанийн мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд хүчингүй болдог (АНУ) онцлогтой байна.

Хуулийн этгээдийн гэрчилгээг цаасаар авч болох бөгөөд энэ тохиолдолд нэмэлт төлбөр төлнө.

Дэлхийн нийтээрээ цахимд шилжиж буй нөгөө талаас төрийн үйлчилгээг хурдан шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх зорилгоор бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулах үйл явц эрчимжиж байгаагийн нэг нь хуулийн этгээдийг бүртгүүлэх, тайлан гаргах, хянах үйл явц бүрэн цахимжиж байна. Судалгаанд авагдсан улсуудын хувьд, хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой бүх үйл явцыг цахимаар гүйцэтгэж байна.

Хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, удирдах зөвлөлийн мэдээллийг бүртгэлийн байгууллагад заавал бүртгүүлнэ. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хувьд мөн бүртгэлийн байгууллагад заавал бүртгүүлэх үүрэгтэй.

Их Британи, АНУ, Франц, Нидерланд улсуудад төрийн бус байгууллага (ТББ)-ыг ихэвчлэн буяны байгууллага, холбоо, ашгийн бус корпорацитай хэлбэрээр бүртгэж, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, ашгийн бус үйл ажиллагаа явуулахыг хуульчлан зохицуулсан байна.

Харин хоршоог гишүүдийн эдийн засгийн хамтын ашиг сонирхлыг хангах зорилготой байгууллага болгон бүртгэж, ашгийн хуваарилалтыг хязгаарлаж, гишүүдийн оролцоог чухалчилсан зохицуулалттай байна. Хоршооны бүртгэлд гишүүдийн мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгө, үйл ажиллагааны төлөвлөгөөг багтааж, худалдааны, эсхүл санхүүгийн зохицуулалтын байгууллагуудад бүртгүүлж, албан ёсны гэрчилгээ авдаг нийтлэг зохицуулалттай байна.

## ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

### НЭГ.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙГ БҮРТГЭХ

Эцсийн өмчлөгчийг тодорхойлох, бүртгэх, хянах зохицуулалт нь улс орнуудын авлига, мөнгө угаах, татвараас зайлсхийхтэй тэмцэх бодлогын нэг чухал хэсэг юм. Европын Холбооны гишүүн улсын хувьд Европын Холбооны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой зөвлөмж болон дотоодын хууль тогтоомжийг дагаж мөрдөж байна.

#### 1.1.Эрх зүйн зохицуулалт

Судалгаанд авагдсан улсууд хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг бүртгэх, ил тод болгохтой холбоотой харилцааг олон улсад нийтлэг хэрэглэж буй зөвлөмж, удирдамжийг баримтлахаас гадна дотоодын хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулж байна. Франц болон Нидерланд улс нь Мөнгө угаахтай тэмцэх тухай Европын Холбооны 4 болон 5 дахь удаагийн удирдамжийг дотоодын хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлдэг байна.

Судалгааны энэ хэсэгт хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчтэй холбоотой харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг авч үзсэн болно.

**Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (Их Британи)**-д хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг бүртгэхтэй холбоотой харилцааг 2006 оны Компанийн тухай хууль (Companies act)<sup>1</sup>, 2015 оны Жижиг бизнес, аж ахуй нэгж ба хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль (Small Business, Enterprise and Employment Act)<sup>2</sup> болон 2017 оны Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, мөнгө шилжүүлэх журам (The Money Laundering, Terrorist Financing and Transfer of Funds (Information on the Payer) Regulations)<sup>3</sup>-аар зохицуулдаг.

**Америкийн Нэгдсэн Улс (АНУ)**-ад хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчтэй холбоотой харилцааг 2024 онд хүчин төгөлдөр болсон Компанийн ил тод байдлын тухай хууль (Corporate Transparency Act)-аар зохицуулдаг. Тус хууль нь 2021 онд Үндэсний батлах хамгаалах эрх мэдлийн тухай хууль (National Defense Authorization Act)<sup>4</sup>-ийн бүрэлдэхүүн болж батлагдсан бөгөөд тус хуулийн 5336 дугаар зүйлд ашиг хүртэгч өмчлөгч (beneficial ownership)-ийн мэдээллийг тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулсан.

**Франц Улс** нь хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчтэй холбоотой харилцааг Мөнгө угаахтай тэмцэх тухай Европын Холбооны 4 болон 5 дахь удаагийн удирдамж (Directive (EU) 2015/849, Directive (EU) 2018/843), Худалдааны хууль (Code de commerce- R.561-55), “Эцсийн өмчлөгчийн бүртгэлийн тогтоол (Decree No. 2017-1094 (UBO Register Decree)), Мөнгө, санхүүгийн тухай хуулийн L561-2-2 дугаар зүйл (Article L561-2-2 of the Monetary and Financial Code)<sup>5</sup>-аар зохицуулдаг. Тус улс Мөнгө угаахтай тэмцэх тухай Европын Холбооны 4 болон 5 дахь удаагийн удирдамжийг үндэсний хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлдэг.

<sup>1</sup> Их Британи: Компанийн тухай хууль (2006). Хандах

<https://www.legislation.gov.uk/ukpga/2006/46/contents>

<sup>2</sup> Их Британи: Жижиг бизнес, аж ахуйн нэгж ба хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль (2015). Хандах

<https://www.legislation.gov.uk/ukpga/2015/26/contents>

<sup>3</sup> Их Британи: Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх, мөнгө шилжүүлэх журам (2017). Хандах

<https://www.legislation.gov.uk/ukxi/2017/692/contents>

<sup>4</sup> АНУ: Үндэсний батлах хамгаалах эрх мэдлийн тухай хууль (2021). Хандах

<sup>5</sup> Франц: Мөнгө санхүүгийн тухай хууль (2025). Хандах

[https://www.legifrance.gouv.fr/codes/texte\\_lc/LEGITEXT000006072026/](https://www.legifrance.gouv.fr/codes/texte_lc/LEGITEXT000006072026/)

**Нидерланд Улс** нь хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчтэй холбоотой харилцааг Мөнгө угаахтай тэмцэх тухай Европын Холбооны 4 болон 5 дахь удаагийн удирдамж (Directive (EU) 2015/849 ба Directive (EU) 2018/843)<sup>6</sup>, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (Dutch Anti-Money Laundering and Terrorism Financing (Prevention) Act)<sup>7</sup>, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн журам (Uitvoeringsbesluit Wwft 2018)<sup>8</sup> болон Эцсийн өмчлөгчийн бүртгэлийн талаарх практик гарын авлага (Greenberg Traurig LLP)<sup>9</sup> зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг дагаж мөрддөг. Эцсийн өмчлөгчийн бүртгэлийг бий болгох, мэдээллийг бүртгэж хадгалах үүргийг Мөнгө угаахтай тэмцэх тухай Европын Холбооны 4 болон 5 дахь удаагийн удирдамжийн дагуу 2020 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн.

## 1.2.Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн тухай

Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч нь тухайн хуулийн этгээдийг өмчилдөг, хяналт тавьдаг хувь хүн юм. Мөн хувьцаа эзэмдэг гэсэн нэрийдлээр итгэмжлэгдсэн этгээд, зуучлагчаар дамжуулан хяналт хэрэгжүүлж буй этгээд ч байж болно. Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (FATF)-аас гаргасан зөвлөмжийн<sup>10</sup> 10-т эцсийн өмчлөгч гэж хуулийн этгээдийг шууд болон шууд бусаар өмчилж буй хувь хүнийг хэлнэ гэж тодорхойлжээ. Дэлхийн улсууд тус байгууллагаас гаргасан зөвлөмжид заасны дагуу хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг тодорхойлох, бүртгэх, хяналт тавих ажлыг зохион байгуулж байна.

Судалгаанд хамрагдсан улсуудад хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн талаарх ойлголт нь ижил боловч түүнийг тодорхойлсон нэр томъёо нь өөр өөр байна (Хүснэгт 1).

*Хүснэгт 1 ЭӨ-нэр томъёоны тодорхойлолт (Их Британи, АНУ, Франц, Нидерланд)*

| Улсын нэр  | Нэр томъёо   | Тодорхойлолт   |
|------------|--|--|
| Их Британи | People with significant control<br>Нөлөө бүхий хяналттай хүн | - Компанийн 25%-аас дээш хувьцаа эзэмшдэг;<br>- Саналын эрхийн 25%-аас дээш хувийг эзэмшдэг;<br>- Компанийг удирдах, хянахад шууд буюу шууд бус байдлаар нөлөөлдөг.  |
| АНУ        | beneficial ownership<br>ашиг хүртэгч өмчлөгч                 | - 25% буюу түүнээс дээш өмчлөх эрх эзэмшдэг, эсхүл;<br>- Компанийн үйл ажиллагаанд бодит хяналт хэрэгжүүлдэг хүн (захирал, түүний үүрэг гүйцэтгэгч, бодит удирдлага хэрэгжүүлдэг этгээд).                                  |
| Франц      | bénéficiaire effectif<br>Эцсийн өмчлөгч                      | - Компанийн 25%-аас дээш хувьцааг шууд болон шууд бусаар эзэмшдэг хувь хүн;<br>- Удирдлагад нөлөө үзүүлж, хяналт тогтоосон хувь хүн;<br>- Байршлыг нуусан бүтэц (offshore, trust гэх мэт)-ийн ард байгаа жинхэнэ хувь хүн. |
| Нидерланд  | Ultimate Beneficial Owner (UBO)<br>Эцсийн өмчлөгч            | - тухайн хуулийн этгээдэд шууд болон шууд бусаар 25%-аас дээш хувийн өмчлөл, саналын эрх, эсхүл бодит хяналт хэрэгжүүлж буй хувь хүн;<br>- 25%-аас доош эзэмшдэг ч бодит хяналт хэрэгжүүлж байгаа хувь хүн.                |

<sup>6</sup> Европын холбоо: Европын холбооны Мөнгө угаахтай тэмцэх 4 дүгээр удирдамж (2015). Хандах <https://eur-lex.europa.eu/eli/dir/2015/849/oj/eng>

<sup>7</sup> Нидерланд: Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2008). Хандах <https://wetten.overheid.nl/BWBR0024282/2025-03-01>

<sup>8</sup> Нидерланд: Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 2018 оны хэрэгжилтийн журам (2018). Хандах <https://chatgpt.com/c/67ff0a89-f89c-8008-a9d8-a6f05ec9b001>

<sup>9</sup> Нидерланд: Эцсийн өмчлөгчийн бүртгэлийн талаарх практик гарын авлага (2024). Хандах [https://www.gtlaw.com/-/media/files/insights/published-articles/2022/04/1\\_ultimate-beneficial-owner-ubo-register-registration-and-maintenance-the-netherlands-\(1\).pdf](https://www.gtlaw.com/-/media/files/insights/published-articles/2022/04/1_ultimate-beneficial-owner-ubo-register-registration-and-maintenance-the-netherlands-(1).pdf)

<sup>10</sup> FATF: Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллагын зөвлөмж (2025). Хандах <https://www.fatf-gafi.org/content/dam/fatf-gafi/recommendations/FATF%20Recommendations%202012.pdf.coredownload.inline.pdf>

**Их Британид** Компанийн тухай хуулийн 21А зүйлд “нөлөө бүхий хяналттай хүн (People with significant control, PSC)”-ийг тодорхойлж, бүртгэлтэй холбоотой харилцааг зохицуулсан. Нөлөө бүхий хяналттай хүн нь дараах шалгуурын аль нэгийг хангасан хувь хүн байна. Үүнд:

- компанийн 25%-аас дээш хувьцаа эзэмшдэг;
- саналын эрхийн 25%-аас дээш хувийг эзэмшдэг;
- компанийг удирдах, хянахад шууд болон шууд бусаар нөлөөлдөг.

**АНУ**-ын Компанийн ил тод байдлын тухай хуулийн 5336 дугаар зүйлд ашиг хүртэгч өмчлөгч (beneficial ownership) гэж дараах нөхцөлийг хангаж буй хувь хүн байна. Үүнд:

- 25% буюу түүнээс дээш өмчлөх эрх эзэмшдэг, эсхүл;
- компанийн үйл ажиллагаанд бодит хяналт хэрэгжүүлдэг хүн (захирал, түүний үүрэг гүйцэтгэгч, бодит удирдлага хэрэгжүүлдэг этгээд).

**Франц Улсын** Мөнгө, санхүүгийн хуулийн L561-2-2 дугаар зүйлд зааснаар “Эцсийн өмчлөгч (bénéficiaire effectif)” гэж дараах шалгуурын аль нэгийг хангасан хувь хүн байна. Үүнд:

- компанийн 25%-аас дээш хувьцааг шууд болон шууд бусаар эзэмшдэг хувь хүн;
- удирдлагад нөлөө үзүүлж, хяналт тогтоосон хувь хүн;
- байршлыг нуусан бүтэц (offshore, trust гэх мэт)-ийн ард байгаа жинхэнэ хувь хүн.

**Нидерланд Улсын** эцсийн өмчлөгчийн бүртгэлийн талаарх практик гарын авлагад “Эцсийн өмчлөгч (Ultimate Beneficial Owner (UBO))” гэж дараах хувь хүний ойлгоно. Үүнд:

- тухайн хуулийн этгээдэд шууд болон шууд бусаар 25%-аас дээш хувийн өмчлөл, саналын эрх, эсхүл бодит хяналт хэрэгжүүлж буй хувь хүн;
- 25%-аас доош эзэмшдэг ч бодит хяналт хэрэгжүүлж байгаа хувь хүн мөн эцсийн өмчлөгч байж болно.

### 1.3.Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг бүртгүүлэх

Судалгаанд хамрагдсан улсуудад хуулийн этгээдийг бүртгэх, түүнд хяналт тавихтай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан байна. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг бүртгүүлэхдээ дараах нийтлэг мэдээллийг бүртгүүлнэ. Тухайлбал, Эцсийн өмчлөгчийн овог нэр, иргэншил, төрсөн огноо, оршин суугаа хаягийг заавал бүртгүүлэх бөгөөд оршин суугаа улс (Их Британи, Нидерланд), эзэмшиж, өмчилж буй хувь хэмжээ (Франц, Нидерланд), хяналтын төрөл (Их Британи, Франц) болон иргэний үнэмлэх/жолооны үнэмлэхний дугаар (АНУ, Нидерланд)-ыг мөн бүртгэдэг байна. Харин Их Британид эцсийн өмчлөгч болсон хугацааг бүртгүүлдэг онцлогтой.

Эцсийн өмчлөгчийн мэдээллийг бүртгүүлэх хугацааны хувьд, судалгаанд авагдсан улсууд харилцан адилгүй зохицуулалттай байна. Их Британи, АНУ, Франц улс нийтдээ 30 хоногт багтаан улсын бүртгэлд бүртгүүлдэг бол Нидерланд улсын хувьд хуулийн этгээдийг анх бүртгүүлэхдээ бүртгүүлдэг байна. Дэлгэрэнгүй мэдээллийг (Хүснэгт 2)-оос үзнэ үү.

**Хүснэгт 2 Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг бүртгүүлэх хугацаа**

| Их Британи  | АНУ  | Франц  | Нидерланд  |
|---|--|--|--|
| Нөлөө бүхий хяналттай хүн"-ийг тодорхойлсон огнооноос хойш 14 хоногийн дотор тухайн компанийн дотоод бүртгэлд, түүнээс хойш 14 хоногийн дотор улсын бүртгэлд буюу нийт 28 хоног | 2025 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойш байгуулагдсан хуулийн этгээдүүд: бүртгэл хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор. | Хуулийн этгээд байгуулагдсанаас хойш 15 хоногийн дотор, өөрчлөлт гарсан тохиолдолд 30 хоногийн дотор | Эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг хуулийн этгээд үүсгэн байгуулж, бүртгүүлэх үедээ хамт бүртгүүлнэ. |

**Их Британид** Компанийн тухай хуулийн 790K-д нөлөө бүхий хяналттай хүнийг бүртгэхэд дараах мэдээллийг бүртгүүлэхээр заасан. Үүнд:

1. нөлөө бүхий хяналттай хүний бүтэн нэр;
2. нөлөө бүхий хяналттай хүний байнга оршин суугаа улс эсхүл Их Британийн хэсэг;
3. нөлөө бүхий хяналттай хүний иргэншил;
4. нөлөө бүхий хяналттай хүний төрсөн **огноо**;
5. нөлөө бүхий хяналттай хүний хувийн оршин суугаа хаяг (энэ мэдээлэл нь олон нийтэд харагдахгүй);
6. тухайн хүн “Нөлөө бүхий хяналттай хүн” болсон огноо;
7. нөлөө бүхий хяналттай хүний компанид үзүүлж буй хяналтын төрөл, жишээлбэл:
  - 25%-иас дээш хувьцаа эзэмшдэг эсэх;
  - 25%-иас дээш саналын эрхтэй эсэх;
  - Компанийн удирдлагад нөлөөлөх эрхтэй эсэх;
8. хэрэв “Нөлөө бүхий хяналттай хүн” нь мэдээллээ олон нийтэд ил гаргахгүй байх хамгаалалт хүссэн бол энэ талаар тэмдэглэнэ.

Бүртгүүлэх хугацааны хувьд, “Нөлөө бүхий хяналттай хүн”-ийг тодорхойлсон **өдрөөс** хойш 14 хоногийн дотор тухайн компанийн дотоод бүртгэлд, түүнээс хойш 14 хоногийн дотор “Companies House”-д мэдээллийг мэдүүлэх бөгөөд нийтдээ 28 хоногийн дотор бүртгүүлэх үүрэгтэй. Тус цахим хуудаст бүртгүүлсэн мэдээлэл нь олон нийтэд нээлттэй байдаг.

**АНУ-д Ашиг хүртэгч өмчлөгчийг** АНУ-д бүртгэлтэй, эсхүл АНУ-д бизнес эрхэлдэг ХХК (LLC), корпораци болон бусад ижил төстэй байгууллагууд тайлагнах үүрэгтэй бөгөөд ашиг хүртэгч өмчлөгчийг бүртгүүлэхдээ дараах мэдээллийг бүртгүүлнэ. Үүнд:

- өмчлөгчийн бүтэн нэр;
- төрсөн огноо;
- байнгын оршин суугаа хаяг;
- иргэний үнэмлэх, эсхүл жолооны үнэмлэхний дугаар.

Эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг дараах хугацаанд бүртгүүлэхээр журамласан.

- 2024 оны 1-р сарын 1-ний **өдрөөс** өмнө байгуулагдсан хуулийн этгээдүүд: 2025 оны 1-р сарын 1-ний **өдрийн** дотор бүртгэлээ хийж дуусгах;
- 2024 онд байгуулагдсан хуулийн этгээдүүд: бүртгэл хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 90 хоногийн дотор;
- 2025 оны 1-р сарын 1-ний **өдрөөс** хойш байгуулагдсан хуулийн этгээдүүд: бүртгэл хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор.

**Франц Улсын** Эцсийн өмчлөгчийн бүртгэлийн **тухай** тогтоолд зааснаар эцсийн өмчлөгчийг бүртгүүлэхэд маягт (CERFA № 16062\*01)-д заасан дараах мэдээллийг бүртгүүлнэ. Үүнд:

- овог нэр;
- төрсөн огноо, газар;
- оршин суугаа хаяг;
- иргэншил;
- шууд болон шууд бусаар эзэмшиж буй эзэмшлийн хувь хэмжээ;
- өмчлөл, хяналтын хэлбэр.

Эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг шинээр байгуулагдсан хуулийн этгээд байгуулагдсанаас хойш 15 хоногийн дотор, өөрчлөлт гарсан тохиолдолд 30 хоногийн дотор бүртгүүлэх үүрэгтэй.

**Нидерланд Улсад** эцсийн өмчлөгчийн дараах мэдээллийг бүртгүүлнэ. Үүнд:

- эцсийн өмчлөгчийн нэр, төрсөн огноо;
- оршин суугаа улс, иргэншил;
- өмчлөл, саналын эрхийн хувь хэмжээ;
- төрсөн газар, улс, гэрийн хаяг;
- иргэний бүртгэлийн дугаар (BSN) буюу гадаадын татварын дугаар;
- бусад: паспорт, гэрчилгээ, хувьцаа эзэмшигчдийн жагсаалт, дүрэм, гэрээ, байгууллагын бүтэц.

Эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг хуулийн этгээд үүсгэн байгуулж, бүртгүүлэх үедээ хамт бүртгүүлнэ.

#### 1.4.Хуулийн этгээдийн бүртгэлийн байгууллага

Хуулийн этгээдийг бүртгэх бүртгэлийн байгууллагын хувьд худалдааны асуудал эрхэлсэн байгууллага энэхүү чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Харин бүртгэх хэлбэрийн хувьд, нийтлэг цахимаар бүртгүүлэх бөгөөд зарим тохиолдолд цаасан хэлбэрийг шуудангаар илгээдэг. Харин бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн мэдээллийн ил тод байдлын хувьд Их Британи олон нийтэд нээлттэй, АНУ, Франц, Нидерланд улс олон нийттэй хаалттай байна. Гэхдээ хууль хяналтын байгууллага болон санхүүгийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан танилцах эрхтэй байна. Нарийвчилсан мэдээллийг (Хүснэгт 3)-аас танилцана уу.

**Хүснэгт 3 Хуулийн этгээдийн бүртгэлийн байгууллага, бүртгэх хэлбэр, мэдээллийн ил тод байдал**

|                                 | Их Британи  | АНУ   | Франц   | Нидерланд   |
|---------------------------------|---|---|---|---|
| <b>Бүртгэлийн байгууллага</b>   | “Companies House”<br>Компанийн бүртгэлийн байгууллага   | FinCEN буюу Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ  | Grefe du Tribunal de commerce буюу Худалдааны шүүхийн бүртгэлийн алба   | Chamber of Commerce буюу Худалдааны танхим  |
| <b>Бүртгэх хэлбэр</b>           | Цахимаар эсхүл цаасаар  | Цахимаар  | Цахимаар  | Цахимаар  |
| <b>Мэдээллийн ил тод байдал</b> | Тус цахим платформ оруулсан мэдээлэл олон нийтэд нээлттэй. Гэхдээ олон нийтэд ил болгохгүй байх хамгаалалтын хүсэлт гаргаж болно. | Олон нийтэд хаалттай. Зөвхөн дараах этгээд нэвтрэх эрхтэй.<br>-Хууль сахиулах болон татварын эрх бүхий байгууллага;<br>-Санхүүгийн байгууллагууд;<br>-Үндэсний аюулгүй байдлын байгууллага. | Олон нийтэд хаалттай. Зөвхөн дараах этгээд нэвтрэх эрхтэй.<br>-Санхүүгийн хяналт, татварын байгууллага;<br>-Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллага;<br>-Хуулийн этгээдийн хууль ёсны төлөөлөгч, нотариат, хуульч;<br>-Хуульд заасан тодорхой мэргэжлийн этгээдүүд (мөнгө угаахтай тэмцэх шалгалт хийдэг хүмүүс). | Олон нийтэд хаалттай. Зөвхөн хууль сахиулах байгууллага болон хууль ёсны зөвшөөрөлтэй байгууллагууд мэдээлэл авах эрхтэй. |

**Их Британид** “Нөлөө бүхий хяналттай хүн”-ийг бүртгэх нь компанийн хууль зүйн үүрэг бөгөөд “Companies House”-д мэдээлэх ёстой. “Companies House”<sup>11</sup> гэдэг нь тус улсын компанийн бүртгэлийн байгууллага юм. Бүх хуулийн этгээд “Нөлөө бүхий хяналттай хүн”-ий талаарх мэдээллийг цахимаар эсхүл цаасан хэлбэрээр тус байгууллагад бүртгүүлэх бөгөөд бүртгэлийг анх компани үүсгэн байгуулахад болон өөрчлөлт орсон үед гэсэн хоёр төрлөөр бүртгүүлнэ. Жишээлбэл, компани анх бүртгүүлэхэд “Нөлөө бүхий хяналттай хүн”-ий мэдээллийг IN01 маягаар бүртгүүлэх бол өөрчлөлт орсон тохиолдолд “PSC-specific form”-уудыг цахимаар бөглөж бүртгүүлнэ.

<sup>11</sup> Их Британи: Companies House цахим хуудас. Хандах <https://www.gov.uk/government/organisations/companies-house> Хандсан огноо: 2025-04-10

**АНУ-д** Ашиг хүртэгч өмчлөгчийн талаарх мэдээллийг Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ (Financial Crimes Enforcement Network) <sup>12</sup> буюу FinCEN-д цахимаар бүртгүүлдэг. Энэхүү байгууллага нь АНУ-ын Сангийн яамны дэргэд байх бөгөөд тус байгууллагын сүлжээнд бүртгүүлсэн мэдээлэл нь олон нийтэд хаалттай байдаг. Зөвхөн дараах этгээдүүд нэвтрэх эрхтэй. Үүнд:

- хууль сахиулах болон татварын эрх бүхий байгууллага;
- санхүүгийн байгууллагууд;
- үндэсний аюулгүй байдлын байгууллага.

**Франц Улсад** эцсийн өмчлөгчийн мэдээллийг орон нутгийн худалдааны шүүхийн бүртгэлийн алба (Greffé du Tribunal de commerce)-д бүртгүүлэх бөгөөд цахимаар бүртгүүлж болно. Энэхүү бүртгэл нь 2020 оноос өмнө олон нийтэд нээлттэй байсан бөгөөд Европын шүүхийн 2022 оны шийдвэрээр олон нийтэд нээлттэй байх нь хүний эрх зөрчиж болзошгүй гэсэн үндэслэлээр олон нийтэд хаалттай болсон. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээлэлд хандах эрх бүхий байгууллагуудыг Европын Холбооны мөнгө угаахтай тэмцэх тухай 4 болон 5 дугаар удирдамжид заасны дагуу дараах байдлаар тогтоосон. Үүнд:

- санхүүгийн хяналт, татварын байгууллага;
- хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллага;
- хуулийн этгээдийн хууль ёсны төлөөлөгч, нотариат, хуульч;
- хуульд заасан тодорхой мэргэжлийн этгээдүүд (мөнгө угаахтай тэмцэх шалгалт хийдэг хүмүүс).

**Нидерланд Улсын** Худалдааны танхим (Chamber of Commerce) нь Нидерландын Сангийн яам, Хууль зүй, аюулгүй байдлын яамны нэрийн өмнөөс эцсийн өмчлөгч болон “Trust”-ын бүртгэлийн мэдээллийг цахимаар бүртгэж, хадгалах үүрэг хүлээдэг.

Эцсийн өмчлөгч нь прокуророос “хамгаалах шаардлагатай этгээд” гэж бүртгэлд бүртгэсэн бол түүний мэдээллийг олон нийтээс 5 жилийн хугацаатайгаар нууцалж болохоор зохицуулалттай байсан бөгөөд Европын Холбооны шүүхээс 2022 онд гаргасан шийдвэрийн дагуу эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг олон нийтэд хаалттай болгосон бөгөөд хууль сахиулах байгууллага болон хууль ёсны зөвшөөрөлтэй байгууллагууд мэдээлэл авах эрхтэй.

## ХОЁР.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ОНООСОН НЭРИЙГ БАТАЛГААЖУУЛАХ

Судалгаанд авагдсан улсуудад хуулийн этгээдийн нэр авахдаа нэрийн давхардлыг заавал шалгах бөгөөд цахим системээс нэрээ шалгана. Зарим нэр авахад тусгай шаардлага тавьдаг байна. Жишээлбэл, Их Британид Royal, Bank, Institute, Government гэх мэт үг агуулсан бол тусгай зөвшөөрөл шаардлагатай.

Хуулийн этгээдийн нэрийг АНУ болон **Францад** урьдчилан хадгалуулдаг бол Их Британи болон Нидерландад урьдчилан хадгалуулах боломжгүй байна.

**Их Британид** хуулийн этгээдийн оноосон нэртэй холбоотой харилцааг Компанийн тухай хуулиар зохицуулдаг. Хуулийн 53-85 дугаар хэсэгт нэр сонгох, хориглох нэр, өөрчлөлт, 66 дугаар хэсэгт давхардсан, төөрөгдүүлсэн нэрийг талаар, 67-68 дугаар хэсэгт зөвшөөрөл шаарддаг нэр (sensitive words)-ийн талаар зохицуулсан.

Хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулж бүртгүүлэх нь дараах үе шаттай. Тухайлбал:

- **нэрийн давхардлыг шалгах** (Companies House цахим хуудас ашиглан нэрийн давхардлыг шалгана. Нэрийг шалгаад хадгалах боломжгүй.);

<sup>12</sup> АНУ-ын “Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ”-ний цахим хуудас. Хандах <https://www.fincen.gov/boi> Хандсан огноо: 2025-04-11

- **зөвшөөрөл шаарддаг нэр эсэхийг шалгах** (“Royal”, “Bank”, “Institute”, “Government” гэх мэт үг агуулсан бол тусгай зөвшөөрөл шаардлагатай.);
- **нэрийг мэдүүлэгт тусгах** (Компанийн санамж бичиг болон үндсэн дүрэмд оруулна.);
- **цахим бүртгэл хийх** (House Online Service ашиглан бүртгэл хийнэ. Цахим бүртгэлийн төлбөр: £12 (ихэнхдээ 24 цагт багтдаг), Шуудангаар бүртгүүлвэл: £40, 8-10 ажлын өдөрт баталгаажна.);
- **нэрийн баталгаажуулалт** (Бүртгэл амжилттай болсны дараа компанийн бүртгэлийн дугаар, албан ёсны гэрчилгээ олгоно.)

Тус улсын хувьд, хуулийн этгээдийг бүртгэх үед нэрсийн давхардлыг шалгаж, бүртгэлийн процессийн хүрээнд нэрийг баталгаажуулдаг.

**Хүснэгт 4 Хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулах, бүртгүүлэх (Их Британи, АНУ, Франц, Нидерланд)**

| Улс                            | Их Британи                  | АНУ                                       | Франц  | Нидерланд                        |
|--------------------------------|-----------------------------|---|--|----------------------------------|
| Давхардал шалгах байгууллага   | Companies House             | Мужийн төрийн нарийн бичгийн даргын газар | INPI<br>Үйлдвэрлэлийн өмчийн үндэсний хүрээлэн | Худалдааны танхим                |
| Урьдчилан баталгаажуулдаг эсэх | Үгүй                        | Тийм                                      | Тийм   | Үгүй                             |
| Тусгай шаардлагатай эсэх       | Зарим нэрэнд зөвшөөрөл авна | Зарим нэрэнд зөвшөөрөл авна               | Оюуны өмч болон хэлбэрийг тусгах               | Оюуны өмч болон хэлбэрийг тусгах |
| Бүртгэлийн хэлбэр              | Цахим/шуудангаар            | Цахим/шуудангаар                          | Цахим  | Цахим/биечлэн                    |
| Баталгаажуулалтын хугацаа      | Хуулийн этгээдийн гэрчилгээ | Мужийн гэрчилгээ                          | Бүртгэлийн гэрчилгээ                           | Хуулийн этгээдийн гэрчилгээ      |

**АНУ-ын** хувьд, хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулах, бүртгэх үйл явц нь улсын хэмжээнд нэгдсэн стандарт байхгүй бөгөөд төвлөрсөн бус, муж улсуудын хууль тогтоомжоор зохицуулагддаг хэдий ч нийтлэг зарчим, бүтэцтэй байдаг. Жишээ болгож **Калифорни** мужийн корпорацийн хууль (California Corporations Code)<sup>13</sup>-ийн авч үзвэл тус хуулийн 201 дүгээр зүйлд аж ахуй нэгжийн нэр (Business Entity Name Regulations)<sup>14</sup> болон нэр хадгалуулах хүсэлт (name reservation request)<sup>15</sup>-ийн талаар зохицуулсан.

Хуулийн этгээдийн нэрийг бүртгэх нь дараах үе шаттай. Үүнд:

- **нэрийн давхардлыг шалгах** (тус мужийн төрийн нарийн бичгийн даргын газрын цахим хуудаснаас нэрийн давхардлыг шалгана; <https://bizfileonline.sos.ca.gov/search/business>)
- **нэр хадгалуулах (хүсэлт гаргах)** Нэрийг 60 хоногийн хугацаагаар урьдчилан хадгалуулах боломжтой. Хадгалуулах хүсэлтийг дахин нэг удаа 60 хоногоор сунгаж болно. Нэр хадгалуулах хүсэлт \$10-ийн хураамж төлнө. Нэр хадгалуулах хүсэлтийг цахимаар болон шуудангаар, биечлэн гаргаж болно;
- **үүсгэн байгуулах баримт бичигт нэрийг тусгах** (Үүсгэн байгуулах баримт бичиг “Articles of Incorporation”-т сонгосон нэрийг тусгана.);
- **бүртгэл хийх** (Үүсгэн байгуулах баримт бичгийг Калифорни мужийн төрийн нарийн бичгийн даргын газарт мэдүүлж, бүртгэл хийлгэнэ.)

<sup>13</sup> АНУ: Калифорни мужийн корпорацийн код (). Хандах [https://leginfo.legislature.ca.gov/faces/codes\\_displayText.xhtml?lawCode=CORP&division=1.&title=1.&part=&chapter=2.&article](https://leginfo.legislature.ca.gov/faces/codes_displayText.xhtml?lawCode=CORP&division=1.&title=1.&part=&chapter=2.&article)

<sup>14</sup> АНУ: Аж ахуй нэгжийн нэрийн журам (2022). Хандах <https://bpd.cdn.sos.ca.gov/be/forms/name-guidelines-restrictions-2022.pdf>

<sup>15</sup> АНУ: Нэр хадгалуулах хүсэлт (2020). Хандах [https://bpd.cdn.sos.ca.gov/corp/pdf/name-reservation-request-form.pdf?utm\\_source=chatgpt.com](https://bpd.cdn.sos.ca.gov/corp/pdf/name-reservation-request-form.pdf?utm_source=chatgpt.com)

**Франц Улсад** хуулийн этгээдийн нэрийг бүртгэх, баталгаажуулах үйл явцыг Худалдааны хууль (Code de commerce)<sup>16</sup>-аар зохицуулдаг. Тус хуулийн 123-1, 123-9 дүгээр зүйлд нэрийн бүртгэл, шаардлага, хязгаарлалттай холбоотой харилцааг зохицуулсан. Нэр нь бүртгэлтэй бусад нэртэй давхцахгүй байх, “SARL”, “SA”, “SAS” гэсэн зохион байгуулалтын хэлбэрийг илэрхийлэх үгсийг ашиглах шаардлагатай. Хуулийн этгээдийн нэрийг бүртгэх нь дараах үе шаттай. Үүнд:

- **нэрийн давхардлыг шалгах:** INPI буюу Үйлдвэрлэлийн өмчийн үндэсний хүрээлэнгийн цахим бүртгэлийн сангаас нэрийн давхардлыг шалгана. Хуулийн этгээдийн нэр болон хэлбэрийг хамтад нь оюуны өмчийн зөрчилтэй эсэхийг шалгана; <https://www.inpi.fr/l-inpi-publie-son-rapport-annuel-2024>
- **нэр хадгалуулах:** Хуулийн этгээдийн нэрийг компанийн дүрэмд тусгаж, бүртгэлийн эхний алхам хийснээр сонгосон нэр нь “factually reserved” төлөвт шилжиж **хадгалагдана**.
- **дүрэмд нэр тусгах:** Дүрэмд хуулийн этгээдийн нэрийг тусгана;
- **бүртгэл хийх:** Шүүхийн харьяа худалдааны бүртгэлийн нэгж (RCS)-д цахимаар мэдүүлгээ бүртгүүлж, Extrait Kbis буюу бүртгэлийн гэрчилгээ авснаар нэр албан ёсоор баталгаажна.

**Нидерланд Улсад** хуулийн этгээдийн нэрийг бүртгэх, баталгаажуулахтай холбоотой харилцааг Иргэний хууль (Burgerlijk Wetboek) болон Худалдааны бүртгэлийн тухай (Handelsregisterwet)<sup>17</sup> хуулиар зохицуулдаг. Худалдааны бүртгэлийн тухай хуулийн 3-5 дугаар зүйлд бүх хуулийн этгээд улсын бүртгэлд заавал **бүртгүүлэхийг хуульчилсан байна**.

Хуулийн этгээдийн нэр бүртгэлтэй бусад нэртэй давхцахгүй байх, “BV”, “NV”, “Stichting” зэрэг зохион байгуулалтын хэлбэрийг илэрхийлэх үгсийг ашиглах, оюуны өмчийн зөрчилгүй байх шаардлага тавигдана. Хуулийн этгээдийн нэрийг бүртгэх үйл явц нь дараах үе шаттай:

- **нэрийн давхардал шалгах:** Худалдааны танхимын цахим системээр нэрийн давхардал шалгана;
- **баримт бичгийг бүрдүүлэх:** Үүсгэн байгуулах гэрээнд нэрийг тусган нотариатаар батлуулна;
- **бүртгүүлэх:** Худалдааны танхимын цахим систем (KvK (Kamer van Koophandel)-д цахимаар болон биечлэн бүртгүүлэх бөгөөд бүртгэлийн хураамж 75 евро байна. Тус цахим хуудаст бүртгүүлэх хүсэлт гаргаснаар хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулж, бүртгэлийн гэрчилгээ болон бизнес эрхлэх татварын дугаар буюу BTW/VA авна.

**Нэрийн баталгаажуулалт нь эцсийн өмчлөгчийг бүртгэхтэй адил хуулийн этгээдийн эрх зүйн хүчин төгөлдөр байдлыг бүрэн хангах суурь нөхцөл болдог тул зохицуулалтын ялгаа, онцлог нь бодлого, хэрэгжилтийн түвшинд чухал ач холбогдолтой юм.**

## ГУРАВ.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТАМГА ТЭМДГИЙН ХЭРЭГЛЭЭ

Судалгаанд авагдсан улсуудын хуулийн этгээдийн тамганы хэрэглээ, зохицуулалтыг авч үзвэл, тамганы хэрэглээний хувьд заавал биш бөгөөд тухайн компани дүрэмдээ заасны дагуу тамга хэрэглэж болно. Компанийн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг зурсан аливаа баримт бичиг хууль зүйн хүчинтэй байна. Түүнчлэн цахим гарын үсэг болон бичгэн

<sup>16</sup> Франц: Худалдааны хууль (2025). Хандах [https://www.legifrance.gouv.fr/codes/texte\\_lc/LEGITEXT000005634379/](https://www.legifrance.gouv.fr/codes/texte_lc/LEGITEXT000005634379/)

<sup>17</sup> Нидерланд: Худалдааны бүртгэлийн тухай хууль (2007). Хандах <https://wetten.overheid.nl/BWBR0021777/2024-10-01>

гарын үсэг нь адил хүчин төгөлдөр байдаг байна. Дэлгэрэнгүй мэдээллийг (Хүснэгт 5) болон судалгаанд авагдсан улсын мэдээллээс үзнэ үү.

**Хүснэгт 5 Хуулийн этгээдийн тамганы зохицуулалт, гарын үсгийн хэрэглээ**

|                                 | <b>Их Британи</b>                         | <b>АНУ</b>  | <b>Франц</b>   | <b>Нидерланд</b>  |
|---------------------------------|---|---|--|---|
| <b>Тамга хэрэглэдэг эсэх</b>    | Энгийн тамгатай байж болно.               | Тамгатай байж болно.  | Тамга нь хууль ёсны байдалд нөлөөлөхгүй                                | Тодорхой зохицуулалт байхгүй  |
| <b>Гарын үсгийн зохицуулалт</b> | Тамгатай нэгэн адил хүчин төгөлдөр байна. | Цахим гарын үсэг нь бичиг баримт баталгаажуулахад хууль ёсны хүчинтэй бөгөөд тамганы оронд ашиглаж болно. | Компанийн баримт бичгийг эрх бүхий хүн гарын үсэг зурж баталгаажуулна. | цахим гарын үсэг нь гараар бичсэн гарын үсэгтэй адил хууль зүйн хүчинтэй. |

**Их Британид** хуулийн этгээдийн тамга (company seal) нь Компанийн тухай хуулийн 45 дугаар зүйлд компани нь энгийн тамга (common seal)-тай байж болох ч заавал байхыг шаардахгүй гэж заажээ. Энгийн тамга дээр компанийн нэр, бүртгэлийн дугаарыг сийлсэн байх ёстой бөгөөд энэ хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу компанийн дүрэмд хэрэглэх журмыг тусгасан байх ёстой. Хэрэв компанийн нэр, бүртгэлийн дугаарыг сийлээгүй тамга хэрэглэсэн компани болон буруутай албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Энгийн тамгатай компани нь Нэгдсэн Хаант Улсаас гадуур ашиглах албан ёсны тамгатай байж **болно. Энэ нь** энгийн тамганы хуулбар байх бөгөөд энгийн тамганы нэгэн адил үйлчилнэ. Албан ёсны тамга дарсан этгээд нь акт болон бусад баримт бичигт тамга дарсан огноо, байршлыг бичгээр баталгаажуулна.

Худалдааны тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасны дагуу **Их Британийн** хуулийн дагуу компани баримт бичгийг баталгаажуулахдаа дараах хэлбэрийг ашиглана.

- а) компанийн тамга хэрэглэх (хэрэв байгаа бол);
- б) гарын үсэг зурах эрх бүхий хоёр этгээд эсхүл гэрчийн гарын үсэг;
- в) компанийн захирал эсхүл ХХК-ны нарийн бичгийн дарга.

Дээр дурдсаны дагуу гарын үсэг зурсан баримт бичиг нь компанийн тамга дарж үйлдсэнтэй адил хүчинтэй.

**АНУ-ын** хувьд, Калифорнийн Иргэний хуулийн<sup>18</sup> 1629 дүгээр зүйлд тамгатай болон тамгагүй баримт бичгийн хооронд ямар ч хууль ёсны ялгаа байхгүй гэж заасан. Харин 1628 дугаар зүйлд тамга хэрэглэх нь зөвшөөрөгдсөн боловч заавал биш бөгөөд гарын үсэг нь баримт бичгийг баталгаажуулахад хангалттай.

Мөн Калифорнийн Корпорацийн кодын 204 (а) дүгээр зүйлд корпораци нь тамга баталж, хэрэглэж, өөрчилж болох ч тамга хэрэглээгүй байх нь баримт бичгийн хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй.

Калифорнийн Цахим гүйлгээний тухай хууль (California Uniform Electronic Transactions Act)<sup>19</sup>-ийн 1633.7 дугаар заалтад цахим гарын үсэг нь бичиг баримт баталгаажуулахад хууль ёсны хүчинтэй бөгөөд тамганы оронд ашиглаж болно.

**Франц Улсад** Худалдааны хуулийн L225-1 дэх заалтад компанийн баримт бичгийг эрх бүхий хүн гарын үсэг зурж баталгаажуулна, тамга нь хууль ёсны хүчинтэй байдалд шаардлагагүй. Иргэний хуулийн 1367 дугаар зүйлд eIDAS буюу Европын Холбооны цахим

<sup>18</sup> АНУ: Калифорни мужийн Иргэний хууль (1872). Хандах [https://leginfo.legislature.ca.gov/faces/codes\\_displayText.xhtml?lawCode=CIV&division=3.&title=2.&part=2.&chapter=&article=](https://leginfo.legislature.ca.gov/faces/codes_displayText.xhtml?lawCode=CIV&division=3.&title=2.&part=2.&chapter=&article=)

<sup>19</sup> АНУ: Калифорни **мужийн** Цахим гүйлгээний тухай хууль (2000). Хандах [https://leginfo.legislature.ca.gov/faces/codes\\_displayText.xhtml?lawCode=CIV&division=3.&title=2.5.&part=2.&chapter=&article=](https://leginfo.legislature.ca.gov/faces/codes_displayText.xhtml?lawCode=CIV&division=3.&title=2.5.&part=2.&chapter=&article=)

гарын үсгийн журам (eIDAS Regulation (EU) No 910/2014:)-д заасан стандарт хангасан цахим гарын үсэг нь гараар бичсэн гарын үсэгтэй адил хууль зүйн хүчинтэй гэж заасан.

**Нидерланд Улсад** Иргэний хуулийн 3:15а заалтад цахим гарын үсэг ашиглах нь аюулгүй бол цахим гарын үсэг нь гараар бичсэн гарын үсэгтэй адил хууль зүйн хүчинтэй гэж заасан. Мөн 6:227а-д хэрэв гэрээг бичгээр байгуулахыг хуулиар шаардсан бол цахим хэлбэрээр байгуулсан гэрээ нь дараах шаардлагыг хангасан байна.

- гарын үсэг зурсан хүн тодорхой байх;
- баримтын бүрэн бүтэн байдал хангагдсан байх;
- гэрээний талууд цахим гарын үсэг хэрэглэхийг зөвшөөрсөн байх.

Нидерланд Улс нь Европын Холбооны гишүүн улс тул eIDAS буюу Европын Холбооны цахим гарын үсгийн журам (eIDAS Regulation (EU) No 910/2014:)<sup>20</sup>-ыг хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, eIDAS стандарт хангасан цахим гарын үсэг нь гараар бичсэн гарын үсэгтэй адил хууль зүйн хүчинтэй гэж заасан.

## ДӨРӨВ.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЦАХИМ ГЭРЧИЛГЭЭ

Судалгаанд хамрагдсан улсуудын зохицуулалтаас үзэхэд хуулийн этгээдийн гэрчилгээ нь цахим болон цаасан гэсэн хоёр хэлбэртэй байна. Цахим хэлбэрийг хуулийн этгээдийн бүртгэлийн байгууллагад бүртгүүлснээр PFD хэлбэрээр татан авах боломжтой бөгөөд цахим хэлбэр нь хууль ёсны хүчин төгөлдөр байх бөгөөд зарим улсад дижитал баталгаажуулалттай (АНУ, Нидерланд) байдаг байна. Хуулийн этгээдийн гэрчилгээ нь компанийн талаарх албан ёсны мэдээллийг агуулж байдаг тул 6-10 сарын хугацаанд хүчинтэй байх (АНУ, Нидерланд), эсхүл компанийн мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд хүчингүй болдог (АНУ) онцлогтой байна.

Хуулийн этгээдийн гэрчилгээг цаасаар авч болох бөгөөд энэ тохиолдолд нэмэлт төлбөр төлж авна.

**Их Британид** хуулийн этгээдийн гэрчилгээ (Certificate of Incorporation) нь цахим болон цаасан хэлбэртэй. Компанийн тухай хуулийн 15 дугаар зүйлд гэрчилгээ нь компанийн нэр, бүртгэлийн дугаар, бүртгэлийн огноог агуулна. Гэрчилгээний хэлбэр нь цаасан болон цахим хэлбэртэй байна.

Companies House цахим системээр дамжуулан гэрчилгээг PDF хэлбэрээр хүлээн авна. Цахим гэрчилгээ нь албан ёсны баримт бичиг бөгөөд хууль ёсны хүчинтэй. Хэрэв бүртгэлийг цаасан хэлбэрээр авахаар хүсэлт гаргасан бол нэмэлт төлбөртэйгээр захиалж авч болно.

**АНУ-ын** Калифорни мужид хуулийн этгээдийн гэрчилгээ (Certificate of Status) нь хуулийн этгээд Калифорни мужид бүртгэлтэй, хууль ёсны үйл ажиллагаа явуулах эрхтэй, татварын өргүй, бүртгэлийн шаардлага хангасан гэдгийг баталгаажуулж олгодог бичиг баримт юм. Тус гэрчилгээ нь цахим болон цаасан хэлбэртэй. Цахим хэлбэрийг PDF хэлбэрээр бүртгэлийн байгууллагын цахим хуудаснаас татаж авах бөгөөд энэ нь албан ёсны баримт бөгөөд дижитал баталгаажуулалттай. Цаасан хувилбарыг мужийн Төрийн нарийн бичгийн даргын газраас биечлэн эсхүл шуудангаар захиална. Гэрчилгээний төлбөр 5-10 ам.доллар байна. Гэрчилгээний хүчинтэй хугацаа 6-1 жил байх бөгөөд хэрэв компанийн төлөв өөрчлөгдсөн тохиолдолд (жишээ нь татварын өр, бүртгэл цуцлагдах гэх мэт) гэрчилгээ хүчингүй болно.

<sup>20</sup> Европын Холбоо: Цахим гарын үсгийн журам (2014). Хандах <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32014R0910>

**Франц Улсад** Худалдааны хуулийн L123-1 дүгээр зүйлд хуулийн этгээдийн гэрчилгээг Худалдааны шүүхийн бүртгэлийн хэлтэст бүртгүүлж авна гэж заасан. Гэрчилгээг тус байгууллагын цахим хуудаснаас PDF хэлбэрээр татаж авах бөгөөд хууль зүйн хүчинтэй. Хэрэв цаасан хэлбэрээр авах бол нэмэлт төлбөртэйгээр захиалж авна.

**Нидерланд Улсад** Худалдааны хуулийн 2:5 дугаар зүйлд компанийн бүртгэлийг Худалдааны танхим хийж, бүртгэлийн гэрчилгээ авна. Гэрчилгээ нь цаасан болон цахим хэлбэртэй байна. Цахим гэрчилгээг PDF хэлбэрээр бүртгэлийн байгууллагын цахим хуудаснаас татаж авна. Цахим хувилбар нь албан ёсны баримт бичиг бөгөөд хууль ёсны хүчинтэй. Цаасан хувилбарыг биечлэн болон шуудангаар хүлээн авч болно. Цаасан хувилбарыг нэмэлт төлбөртэй авах бөгөөд 15-20 евро байдаг. Хуулийн этгээдийн гэрчилгээ нь хуулийн этгээдийн хамгийн сүүлийн үеийн мэдээллийг агуулдаг бөгөөд гэрчилгээний хуулбар нь 6-1 жилийн хугацаанд хүчинтэй байдаг. Цахим хувилбар нь бүртгэлийн байгууллагын дижитал баталгаажуулалттай байдаг.

## ТАВ.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЦАХИМ БҮРТГЭЛИЙН СИСТЕМ

Дэлхийн нийтээрээ цахимд шилжиж буй нөгөө талаас төрийн үйлчилгээг хурдан шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх зорилгоор бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулах үйл явц эрчимжиж байгаагийн нэг нь хуулийн этгээдийг бүртгүүлэх, тайлан гаргах, хянах үйл явц бүрэн цахимжиж байна. Судалгаанд авагдсан улсуудын хувьд, хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой бүх үйл явцыг цахимаар гүйцэтгэж байна.

**Их Британи:** Системийн нэр: Companies House (Холбоос: [Companies House](#))

Их Британийн хуулийн этгээдийн бүртгэлийг Companies House хариуцдаг бөгөөд энэ нь компанийн бүртгэл, тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг хангадаг төв байгууллага юм. Цахим системээр дамжуулан компани байгуулах, жилийн тайлан ирүүлэх, хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг шинэчлэх боломжтой. Мэдээлэл нь олон нийтэд нээлттэй бөгөөд ихэнх мэдээллийг **цахимаар** үнэ төлбөргүй авах боломжтой. Онцлог:

- компанийн нэр, бүртгэлийн дугаар, директорын мэдээлэл, санхүүгийн тайлан зэргийг бүртгэдэг;
- Gov.uk порталаар дамжуулан бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулсан;
- People with Significant Control (PSC) бүртгэлээр эцсийн өмчлөгчдийн ил тод байдлыг хангана.

**АНУ:** Системийн нэр: California Business Portal / Secretary of State Business Programs (Холбоос: [California Secretary of State](#))

Калифорни мужийн хуулийн этгээдийн бүртгэлийг Калифорни мужийн Төрийн нарийн бичгийн даргын газар (Secretary of State) хариуцдаг. Business Programs хэлтэс нь корпораци, хязгаарлагдмал хариуцлагатай компани (LLC), түншлэл зэргийн бүртгэлийг удирддаг. Цахим системээр дамжуулан бүртгэл, өөрчлөлт, тайлан ирүүлэх боломжтой. Онцлог:

- **Цахим** бүртгэлийн систем (bizfile Online) нь бүртгэлийн үйл явцыг хялбаршуулдаг.
- Мэдээллийн мэдэгдэх хуудсаар тайланг тогтмол ирүүлэх шаардлагатай.
- Бизнесийн нэрний хайлт, бүртгэлийн статусыг **цахимаар** шалгах боломжтой.

**Франц Улс:** Системийн нэр: Infogreffe Холбоос: [Infogreffe](#))

Франц Улсын хуулийн этгээдийн бүртгэлийг Infogreffe платформ болон Guichet Unique (нэг цэгийн үйлчилгээ) хариуцдаг. Infogreffe нь компанийн мэдээлэл, санхүүгийн тайлан, хууль ёсны баримт бичгийг олон нийтэд нээлттэй болгодог. Онцлог:

- компанийн бүртгэл, өөрчлөлтийг **цахимаар** хийх боломжтой;

- Registre National des Entreprises (RNE) нь улсын хэмжээнд бизнесийн мэдээллийг нэгтгэдэг;
- мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор санхүүгийн тайлан нийтэд нээлттэй.

**Нидерланд Улс:** Системийн нэр: Худалдааны танхим (KVK) /Business Register (Холбоос: [KVK Business Register](#))

Нидерланд **Улсын** Худалдааны танхим нь хуулийн этгээдийн бүртгэлийг хариуцдаг бөгөөд Business Register (Handelsregister) нь компанийн мэдээллийн төв сан юм. Цахим системээр дамжуулан бизнесийн бүртгэл, өөрчлөлт, тайлан ирүүлэх боломжтой. Онцлог:

- бүх бизнес эрхлэгчид Худалдааны танхимд бүртгүүлэх ёстой;
- Эцсийн өмчлөгчийн (UBO) бүртгэлээр эцсийн өмчлөгчдийн мэдээллийг ил болгодог;
- **цахим** платформаар бүртгэлийн үйлчилгээ, мэдээллийн хайлтыг хялбаршуулсан.

## **ЗУРГАА.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙГ БҮРТГҮҮЛЭХ**

Хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, удирдах зөвлөлийн мэдээллийг бүртгэлийн байгууллагад заавал бүртгүүлнэ. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хувьд мөн бүртгэлийн байгууллагад заавал бүртгүүлэх үүрэгтэй.

**Их Британи: Хувь нийлүүлсэн хөрөнгө:** Компанийн тухай хуулийн 8 зүйл (Share capital).

- хувь нийлүүлсэн хөрөнгө (share capital) нь компанийн бүртгэлийн явцад тодорхойлогдож, Companies House-д бүртгэгдэнэ;
- хувийн хязгаарлагдмал хариуцлагатай компани (Private Limited Company)-д хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээний шаардлага байхгүй;
- тус хуулийн 542 дугаар хэсэг: Компанийн хувьцаа нь хувийн өмч бөгөөд нэрлэсэн үнээр гаргаж болно;
- хувь нийлүүлсэн хөрөнгийн мэдээлэл (нийт хувьцаа, хувьцааны үнэ, ангилал) нь хөрөнгийн мэдэгдэл (Statement of Capital) хэлбэрээр бүртгэгдэнэ.

**Бүртгэлийн процесс:**

- бүртгэлийн маягт (Form IN01)-д хувь нийлүүлсэн хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээллийг оруулж, Companies House-д цахимаар, **эсхүл** цаасаар ирүүлнэ.
- хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг (жишээ нь, хувьцаа нэмэх) Form SH01-ээр мэдээлнэ.

**Гүйцэтгэх захирал/Удирдах зөвлөл:** Компанийн тухай хуулийн 12 дугаар зүйл.(Company directors).

- Тус хуулийн 154 дүгээр зүйл. Хувийн компани нэгээс дээш захиралтай байх ёстой; олон нийтийн компани (PLC) хоёроос дээш захиралтай байх ёстой;
- “Гүйцэтгэх захирал” (CEO) гэсэн тусгай албан тушаал хуулиар заавал шаардахгүй бөгөөд захирлууд (directors) компанийг удирдана;
- захирлуудын мэдээлэл (нэр, хаяг, томилогдсон огноо)-ийг Companies House-д бүртгэгдэнэ.

**Бүртгэлийн процесс:**

- захирлуудын мэдээллийг Form IN01-д оруулж, бүртгэлийн явцад ирүүлнэ;
- захирлын томилгоо, огцорсон тухай мэдээллийг Form AP01 (томилгоо), **эсхүл** TM01 (огцорсон тухай)-ээр мэдээлнэ.

**АНУ: Бүртгэлийн байгууллага: Мужийн төрийн нарийн бичгийн даргын газар**

**Хувь нийлүүлсэн хөрөнгө:** Корпорацийн хуулийн 202 дугаар зүйл, 409 дүгээр зүйл.

- хуулийн этгээдийн гэрчилгээнд хувьцааны тоо, төрлийг заана.
- хувьцаа гаргахыг удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

#### **Бүртгэлийн процесс:**

- удирдах зөвлөлийн анхны хурлаар хувьцаа гаргахыг зөвшөөрч, хувьцаа эзэмшигчдэд хуваарилна;
- хувьцааны бүртгэлийг корпорацийн хувьцааны бүртгэлийн дэвтэрт (stock transfer ledger) хөтөлнө;
- хувьцаа гаргахдаа холбооны болон мужийн хөрөнгийн хууль (Securities Laws)-ийг дагаж мөрдөнө.

#### **Гүйцэтгэх захирал: Зохицуулалт:**

- Корпорацийн тухай хуулийн 312 дугаар зүйл. Корпораци нь гүйцэтгэх захирал эсхүл ерөнхийлөгчтэй байж болно;
- тус хуулийн 17704 дүгээр зүйл. Хуулийн этгээдийн гэрчилгээнд гүйцэтгэх захирлын талаарх мэдээлэл (нэр, байнга оршин суугаа хаяг)-ийг оруулна;
- корпораци байгуулагдсанаас хойш 90 хоногийн дотор, дараа нь жил бүр мужийн төрийн нарийн бичгийн даргын газарт ирүүлнэ.

#### **Удирдах зөвлөл: Зохицуулалт:**

- Корпорацийн тухай хуулийн 301 дүгээр зүйл. Корпораци нь нэгээс дээш удирдах зөвлөлийн гишүүнтэй байх ёстой;
- Мэдээллийн мэдэгдэх хуудаст удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээллийг оруулна.

#### **Бүртгэлийн үйл явц:**

- Мэдээллийн мэдэгдэх хуудас (Form SI-550): Удирдах зөвлөлийн гишүүдийн нэр, хаягийг жил бүр бүртгэнэ;
- анхны гишүүдийн тоог үүсгэн байгуулах баримт бичигт зааж болно;
- удирдах зөвлөлийн гишүүдийн томилгоо, өөрчлөлтийг корпорацийн дотоод бүртгэлд тэмдэглэнэ.

#### **Франц Улс:** Бүртгэлийн байгууллага: **Худалдааны шүүхийн бүртгэл**

#### **Хувь нийлүүлсэн хөрөнгө:** Зохицуулалт: Худалдааны хуулийн L225-1 дүгээр заалтууд.

- хувь нийлүүлсэн хөрөнгө (capital social) нь компанийн бүртгэлийн явцад тодорхойлогдож, компанийн дүрэмд тусгана;
- тус хуулийн L225-3 дугаар заалт. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцааны тоо, ангиллыг дүрэмд заавал тусгана;
- зарим компанийн хэлбэрт доод хэмжээний шаардлага байдаг (жишээ нь, SAS-д доод хэмжээ байхгүй, SA-д €37,000).

#### **Бүртгэлийн процесс:**

- компанийн дүрмийг бэлтгэж, хувь нийлүүлсэн хөрөнгийн мэдээллийг оруулна;
- дүрэм болон бусад баримт бичгийг бүртгэлийн байгууллагад ирүүлж, хуулийн этгээдийн гэрчилгээнд хувь нийлүүлсэн хөрөнгийн мэдээлэл тусгагдана;
- хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг дүрмийн өөрчлөлтөөр бүртгэнэ.

#### **Гүйцэтгэх захирал/Удирдах зөвлөл:**

Зохицуулалт: Худалдааны хуулийн L225-18 дугаар хэсэг (Directors).

- Тус хуулийн L225-18 дугаар хэсэг. Удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлыг томилогдоно;
- гүйцэтгэх захирал, удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл (нэр, томилогдсон огноо)-ийг бүртгэлийн байгууллагад бүртгэж, хуулийн этгээдийн гэрчилгээнд тусгана.

### **Бүртгэлийн процесс:**

Захирал, удирдах зөвлөлийн гишүүдийг томилох шийдвэрийг хувь нийлүүлэгчдийн хурлаар гаргаж, бүртгэлийн маягт (M0, **эсхүл** M3)-аар ирүүлнэ.

**Нидерланд Улс:** Бүртгэлийн байгууллага: Худалдааны танхим

**Хувь нийлүүлсэн хөрөнгө:** Иргэний хуулийн 2 бүлгийн 2:175 хэсэг (Share capital).

- хувь нийлүүлсэн хөрөнгө нь компанийн дүрэмд заагдана.
- тус хуулийн 2:178 хэсэг. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцааны тоо, ангиллыг дүрэмд тусгана.

### **Бүртгэлийн процесс:**

- компанийн дүрмийг нотариатаар баталгаажуулж, хувь нийлүүлсэн хөрөнгийн мэдээллийг оруулна;
- дүрмийг Худалдааны танхимд бүртгүүлэх ба хувь нийлүүлсэн хөрөнгийн мэдээлэлийг тусгана;
- хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг дүрмийн өөрчлөлтөөр бүртгэнэ.

**Гүйцэтгэх захирал/Удирдах зөвлөл:** Иргэний хуулийн 2 бүлгийн 2:129 хэсэгт Компанийг удирдах зөвлөл удирдана; Гүйцэтгэх захирал нь дотоод дүрмээр томилогдоно.

- Удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл (нэр, томилогдсон огноо)-ийг Худалдааны танхимд бүртгүүлнэ.

### **Бүртгэлийн процесс:**

Захирал, удирдах зөвлөлийн гишүүдийг томилох шийдвэрийг хувь нийлүүлэгчдийн хурлаар гаргаж, Худалдааны танхимд бүртгүүлнэ.

## **ДОЛОО.ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ХОРШООГ БҮРТГЭХ ТУХАЙ**

Их Британи, АНУ, Франц, Нидерланд улсуудад **төрийн бус байгууллага** (ТББ)-ыг ихэвчлэн буяны байгууллага, холбоо, ашгийн бус корпорацитай хэлбэрээр бүртгэж, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, ашгийн бус үйл ажиллагаа явуулахыг хуульчлан зохицуулсан байна. Харин хоршоог эдгээр улсуудад гишүүдийн эдийн засгийн хамтын ашиг сонирхлыг хангах зорилготой байгууллага болгон бүртгэж, ашгийн хуваарилалтыг хязгаарлаж, гишүүдийн оролцоог чухалчилсан зохицуулалттай байна. ТББ-ууд нь тухайн улсын төрийн, **эсхүл** орон нутгийн байгууллагуудад дүрэм, зорилго, санхүүгийн төлөвлөгөө, удирдлага болон гишүүдийн мэдээллийг бүртгүүлж, тогтмол мэдээллээ шинэчлэх шаардлагатай байдаг. Хоршооны бүртгэлд гишүүдийн мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгө, үйл ажиллагааны төлөвлөгөөг багтааж, худалдааны, **эсхүл** санхүүгийн зохицуулалтын байгууллагуудад бүртгүүлж, албан ёсны гэрчилгээ авдаг нийтлэг зохицуулалттай байна.

**Их Британид** **ТББ**-ыг ихэвчлэн буяны байгууллага (Charity) эсхүл нийгмийн зорилготой ашгийн бус байгууллага хэлбэрээр бүртгэдэг. Англи, Уэльсийн буяны байгууллагыг 2011 оны Буяны байгууллагын тухай хууль (Charities Act)<sup>21</sup>-аар зохицуулдаг.

Буяны байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлд нийтийн ашиг сонирхлыг хангах зорилготой, ашгийн бус байх ёстой бөгөөд Буяны хороо (Charity Commission)<sup>22</sup>-д цахимаар бүртгүүлнэ. Бүртгүүлэхдээ дүрэм, зорилго, санхүүгийн төлөвлөгөө, итгэмжлэгчдийн

<sup>21</sup> Их Британи: Буяны байгууллагын тухай хууль (2011). Хандах <https://www.legislation.gov.uk/ukpga/2011/25/section/4>

<sup>22</sup> Их Британи: Charity Commission. Хандах <https://www.gov.uk/government/organisations/charity-commission> Хандсан: 2025-04-21

мэдээллийг бүртгүүлнэ. Жилийн орлого 5000 фунт стирлингээс дээш бол заавал бүртгүүлэх шаардлагатай.

Хоршоо: Хоршоо болон нийгмийн ашиг тусын нийгэмлэгийн тухай (Co-operative and Community Benefit Societies Act)<sup>23</sup> 2014 оны хуулиар зохицуулдаг. Тус хуулийн 2 дугаар зүйлд зааснаар хоршоо нь гишүүдийн ашиг сонирхлыг хамгаалах болон нийгмийн зорилготой байж болох бөгөөд Санхүүгийн удирдлагын газар (Financial Conduct Authority)<sup>24</sup>-т цахимаар бүртгүүлнэ. Бүртгүүлэхдээ хоршооны дүрэм, гишүүдийн жагсаалт (нэр, оршин суугаа хаяг, хувьцааны мэдээлэл), санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг бүртгүүлэх бөгөөд тэмдэгтийн хураамж хоршооны төрлөөс хамаарч 40-950 фунт стирлинг байна.

**АНУ-ын** Калифорни мужийн корпорацийн хуулийн 5000 дугаар зүйлүүд болон Калифорни мужийн Засгийн газрын хуулийн 12580–12599.7 зүйлд ашгийн бус буяны байгууллагын талаар зохицуулсан. Төрийн бус байгууллагыг бүртгүүлэхдээ үүсгэн байгуулах баримт бичгийг бүрдүүлж, Төрийн нарийн бичгийн даргын газарт цахимаар эсхүл шуудангаар хүргүүлнэ. Бүртгүүлсний дараа 90 хоногийн дотор мэдээллийн мэдэгдэл хуудас (Statement of Information (Form SI-100))-ыг бөглөх бөгөөд түүнээс хойш хоёр жил тутам мэдээллийг шинэчлэх үүрэгтэй.

Хоршооны тухайд Калифорни мужийн корпорацийн хуулийн 12200 дугаар хэсгээр зохицуулсан. Бүртгүүлэхдээ үүсгэн байгуулах баримт бичгийг бүрдүүлж, Төрийн нарийн бичгийн даргын газарт цахимаар эсхүл шуудангаар хүргүүлнэ. Бүртгүүлсний дараа 90 хоногийн дотор мэдээллийн мэдэгдэл хуудас (Statement of Information (Form SI-100))-ыг бөглөх бөгөөд түүнээс хойш жил бүр мэдээллийг шинэчлэх үүрэгтэй.

**Франц Улсад** төрийн бус байгууллагыг холбоо буюу association хэлбэрээр бүртгэдэг. Төрийн бус байгууллагын үйл ажиллагааг 1901 онд баталсан Холбооны хуулиар<sup>25</sup> зохицуулдаг. Тус хуулийн 2 дугаар зүйлд төрийн бус байгууллага нь ашгийн бус зорилготой, гишүүдийн хамтын үйл ажиллагааг дэмжих байгууллага гэж тодорхойлсон бөгөөд орон нутгийн захиргаанд бүртгүүлнэ. Бүртгүүлэхдээ холбооны дүрэм, зорилго, удирдлага болон гишүүдийн мэдээллийг цахимаар эсхүл цаасан хэлбэрээр илгээнэ. Бүртгэсний дараа бүртгэлийн дугаар (SERIT) олгодог.

Хоршооны хувьд, Худалдааны хуулийн L231-1 дэх хэсэгт хоршоо нь гишүүдийн эдийн засгийн хамтын ашиг сонирхлыг дэмжих зорилготой бөгөөд RCS-т бүртгүүлнэ гэж заасан. Бүртгүүлэхдээ хоршооны дүрэм, хувь нийлүүлсэн хөрөнгө, удирдлагын мэдээллийг бүртгүүлж хуулийн этгээдийн гэрчилгээ авна.

**Нидерланд Улсад** Иргэний хуулийн 2 дугаар бүлгийн 2:26 дугаар хэсэгт холбоо нь гишүүдийн хамтын зорилготой ашгийн бус байгууллага байх бөгөөд Худалдааны танхимд бүртгүүлнэ, 2:285 дугаар хэсэгт сан нь нийгмийн зорилготой байх бөгөөд нотариатын баримтаар бүртгүүлнэ гэж зохицуулжээ. Бүртгүүлэхдээ дүрмийг нотариатаар баталгаажуулж, зорилго, удирдлагын болон гишүүдийн талаарх мэдээллийг Худалдааны танхимд бүртгүүлж, худалдааны танхимын гэрчилгээ авна.

Хоршооны хувьд, Иргэний хуулийн 2 дугаар бүлгийн 2:53 дугаар хэсэгт хоршоо нь гишүүдийн эдийн засгийн ашиг сонирхлыг дэмжих зорилготой бөгөөд Худалдааны танхимд бүртгүүлнэ. Бүртгүүлэхдээ хоршооны дүрмийг нотариатаар баталгаажуулж, хувь нийлүүлсэн хөрөнгө, удирдлага, гишүүдийн талаарх мэдээллийг Худалдааны танхимд бүртгүүлж, гэрчилгээ авна.

<sup>23</sup> Их Британи: Co-operative and Community Benefit Societies Act (2014). Хандах <https://www.legislation.gov.uk/ukpga/2014/14/contents>

<sup>24</sup> Их Британи: Financial Conduct Authority. Хандах <https://www.fca.org.uk/> Хандсан: 2025-04-22

<sup>25</sup> Франц: Loi 1901. Хандах <https://www.legifrance.gouv.fr/loda/id/LEGITEXT000006069570/>

## НОМ ЗҮЙ

### Их Британи Улс

Их Британи: Компанийн тухай хууль (2006). Хандах

<https://www.legislation.gov.uk/ukpga/2006/46/contents>

Их Британи: Жижиг бизнес, аж ахуйн нэгж ба хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль (2015).

Хандах <https://www.legislation.gov.uk/ukpga/2015/26/contents>

Их Британи: Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх, мөнгө шилжүүлэх журам (2017).

Хандах <https://www.legislation.gov.uk/uksi/2017/692/contents>

Их Британи: Companies House цахим хуудас. Хандах

<https://www.gov.uk/government/organisations/companies-house> Хандсан огноо: 2025-04-10

Их Британи: Буяны байгууллагын тухай хууль (2011). Хандах

<https://www.legislation.gov.uk/ukpga/2011/25/section/4>

Их Британи: Charity Commission. Хандах <https://www.gov.uk/government/organisations/charity-commission> Хандсан: 2025-04-21

Их Британи: Co-operative and Community Benefit Societies Act (2014). Хандах

<https://www.legislation.gov.uk/ukpga/2014/14/contents>

Их Британи: Financial Conduct Authority. Хандах <https://www.fca.org.uk/> Хандсан: 2025-04-22

### АНУ

АНУ: Үндэсний батлах хамгаалах эрх мэдлийн тухай хууль (2021). Хандах

АНУ-ын “Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ”-ний цахим хуудас. Хандах

<https://www.fincen.gov/boi> Хандсан огноо: 2025-04-11

АНУ: Калифорни мужийн корпорацийн код (.). Хандах

[https://leginfo.legislature.ca.gov/faces/codes\\_displayText.xhtml?lawCode=CORP&division=1.&title=1.&part=&chapter=2.&article](https://leginfo.legislature.ca.gov/faces/codes_displayText.xhtml?lawCode=CORP&division=1.&title=1.&part=&chapter=2.&article)

АНУ: Аж ахуй нэгжийн нэрийн журам (2022). Хандах

<https://bpd.cdn.sos.ca.gov/be/forms/name-guidelines-restrictions-2022.pdf>

АНУ: Нэр хадгалуулах хүсэлт (2020). Хандах [https://bpd.cdn.sos.ca.gov/corp/pdf/name-reservation-request-form.pdf?utm\\_source=chatgpt.com](https://bpd.cdn.sos.ca.gov/corp/pdf/name-reservation-request-form.pdf?utm_source=chatgpt.com)

АНУ: Калифорни мужийн Иргэний хууль (1872). Хандах

[https://leginfo.legislature.ca.gov/faces/codes\\_displayText.xhtml?lawCode=CIV&division=3.&title=2.&part=2.&chapter=&article=](https://leginfo.legislature.ca.gov/faces/codes_displayText.xhtml?lawCode=CIV&division=3.&title=2.&part=2.&chapter=&article=)

АНУ: Калифорни мужийн Цахим гүйлгээний тухай хууль (2000). Хандах

[https://leginfo.legislature.ca.gov/faces/codes\\_displayText.xhtml?lawCode=CIV&division=3.&title=2.5.&part=2.&chapter=&article=](https://leginfo.legislature.ca.gov/faces/codes_displayText.xhtml?lawCode=CIV&division=3.&title=2.5.&part=2.&chapter=&article=)

### Франц Улс

Франц: Мөнгө санхүүгийн тухай хууль (2025). Хандах

[https://www.legifrance.gouv.fr/codes/texte\\_lc/LEGITEXT000006072026/](https://www.legifrance.gouv.fr/codes/texte_lc/LEGITEXT000006072026/)

Франц: Худалдааны хууль (2025). Хандах

[https://www.legifrance.gouv.fr/codes/texte\\_lc/LEGITEXT000005634379/](https://www.legifrance.gouv.fr/codes/texte_lc/LEGITEXT000005634379/)

Франц: Loi 1901. Хандах <https://www.legifrance.gouv.fr/loda/id/LEGITEXT000006069570/>

### Нидерланд Улс

Нидерланд: Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2008).

Хандах <https://wetten.overheid.nl/BWBR0024282/2025-03-01>

Нидерланд: Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 2018 оны хэрэгжилтийн журам (2018). Хандах <https://chatgpt.com/c/67ff0a89-f89c-8008-a9d8-a6f05ec9b001>

Нидерланд: Эцсийн өмчлөгчийн бүртгэлийн талаарх практик гарын авлага (2024). Хандах [https://www.gtlaw.com/-/media/files/insights/published-articles/2022/04/1\\_ultimate-beneficial-owner-ubo-register-registration-and-maintenance-the-netherlands-\(1\).pdf](https://www.gtlaw.com/-/media/files/insights/published-articles/2022/04/1_ultimate-beneficial-owner-ubo-register-registration-and-maintenance-the-netherlands-(1).pdf)

Нидерланд: Худалдааны бүртгэлийн тухай хууль (2007). Хандах <https://wetten.overheid.nl/BWBR0021777/2024-10-01>

## **Бусад**

Европын холбоо: Европын холбооны Мөнгө угаахтай тэмцэх 4 дүгээр удирдамж (2015).

Хандах <https://eur-lex.europa.eu/eli/dir/2015/849/oj/eng>

FATF: Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллагын зөвлөмж (2025).

Хандах <https://www.fatf-gafi.org/content/dam/fatf-gafi/recommendations/FATF%20Recommendations%202012.pdf.coredownload.inline.pdf>

Европын Холбоо: Цахим гарын үсгийн журам (2014). Хандах <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32014R0910>